



Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

Монгол Улс, Улаанбаатар хот
2022 оны 03 сарын 10

Дэлхийн стартапын экосистем

Дэлхийн венчур санхүүжилтийн хэмжээ 2021 оны эхний хагасын байдлаар **288 тэрбум** ам.долларт хүрчээ (*Дэлхийн стартапын экосистемийн тайлан 2021- Стартап Геном*).

Стартап экосистемийн зорилго нь компаниудыг үүсгэн байгуулах, өсөлт хөгжилд хөтлөх явдал юм. Дэлхий нийтээр үүсгэн байгуулагчид, хөрөнгө оруулагчид амжилтыг дээд хэмжээнд хүргэж, юникорн болгох шилдэг экосистемийг хайж байдаг бол бодлого боловсруулагчид стартапын эдийн засгийн үр нөлөөг нэмэгдүүлэх бодлогын болон зохицуулалтын таатай орчныг бий болгохыг зорьж өрсөлддөг.

Монголын стартапын экосистем

Судалгаанд оролцсон стартапуудын дундаж үнэлгээнд үндэслэн тооцоход **Монгол Улсын стартапын экосистемийн нийт үнэлгээ хамгийн багадаа 424 тэрбум төгрөг** болж байна. Нийт санхүүжилтийн хэмжээ 96 тэрбум төгрөг байна. Судалгаанд хамрагдсан стартапууд эдийн засагт **60 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 1,318 ажлын байрыг** бий болгожээ. Нийт 80 стартап, 10 инкубатор, хурдасгуур, инновацийн төв, бүлэг, 9 их сургууль, технологийн коллеж, судалгааны институт, гол шийдвэр гаргагчид, олон улсын хөгжлийн байгууллагын төлөөлөл энэхүү судалгааны ярилцлагад оролцсон.

Гол таван сорилт

Стартапуудад

- Хүний нөөц бүрдүүлэх (68%)
- Борлуулалт хийх, хэрэглэгчээ олох (54%)
- Хөрөнгө босгох (49%)
- Олон улсын зах зээлд гарах (41%)
- Баг бүрдүүлэх (37%)

Экосистемийн хувьд

- Боловсролтой ажиллах хүч (68%)
- Тогтвортой эдийн засгийн орчин (59%)
- Инновацийн түвшин (41%)
- Хүн амын худалдан авах чадвар (34%)
- Багийн гишүүдийн бэлэн байдал (29%)

Стартапын экосистемийн өсөлтийг хангах зөвлөмжүүд

01

Стартапуудын эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлого, зохицуулалтыг бий болгох

03

Стартапын экосистемийн уялдаа, холбоо, харилцан хамтын ажиллагааг дэмжих

02

Стартап болон хөрөнгө оруулагчдыг дэмжих орчныг бүрдүүлэх

04

Инновац, ажиллах хүчнийг дэмжих ШУТИМ-ын боловсролын шинэтгэлийг

Арга зүй

“Гарааны бизнесүүд нь инноваци дээр суурилж, одоо байгаа бүтээгдэхүүний дутагдлыг арилгах эсвэл бараа, үйлчилгээний цоо шинэ ангиллыг бий болгож, улмаар бүхэл бүтэн салбарыг хамарсан сэтгэх, бизнес эрхлэх хэв маягийг өөрчилдөг” (The Forbes).

Энэхүү үнэлгээнд “стартап”-ыг салбартаа үсрэнгүй өөрчлөлтийг авчрахыг зорьж буй технологид суурилсан гарааны бизнес хэмээн нарийвчлан тодорхойлсон. Бусад экосистемтэй харьцуулахын тулд **шинээр гарч ирж буй экосистемийг** хэмжих Стартап Геном байгууллагын Дэлхийн Стартапын Экосистемийн Тайлангийн (ДСЭТ) аргачлалыг суурь болгон сонгон авсан:

- Гүйцэтгэл;
- Санхүүжилт;
- Зах зээлд нэвтрэлт;
- Туршлага, авьяас мэдлэг;
- Уялдаа холбоо (нэмэлтээр).

Стартапуудыг салбараар ангилахдаа Стартап Геномын ангиллыг ашигласан.

Олон улсын түвшинд экосистемийн үнэлгээнд ашигладаг **гуравдагч талын мэдээллийн сан байхгүй** нь Монголын стартапын экосистемийн үнэлгээнд гарч буй гол дутагдалтай тал болж байна. Тухайлбал, ДСЭТ-д Crunchbase, Dealroom зэргийг гуравдагч талын мэдээллийн эх үүсвэр болгон ашигладаг. Үүний зэрэгцээ, ДСЭТ-д глобал үүсгэн байгуулагчдын судалгаа болон суурь судалгааг ашигладаг.

Гэсэн хэдий ч энэ удаагийн судалгааны арга зүйг стартапын экосистемийн гол оролцогч талуудтай ярилцлага хийх чанар үнэлгээ байдлаар боловсруулсан.


Энэхүү үнэлгээний хүрээнд нийт 80 стартап, 10 хурдасгуур / инкубатор, инновацын төв, 9 их сургууль, технологийн коллеж (KOSEN), олон улсын байгууллагууд, төрийн байгууллагуудын төлөөлөлтэй ярилцлага хийсэн.

Стартапуудын товч танилцуулга

Ерөнхийдөө Монгол Улсын стартап экосистем нь харьцангуй залуу буюу стартапуудын бараг 63 хувь нь сүүлийн 3 жилд үйл ажиллагаа явуулж байгаа стартапууд байна. Тухайлбал, судалгаанд оролцсон стартапуудын 32 хувь нь 2021 онд байгуулагджээ. Хурдасгуур / инкубаторуудын үзэж байгаагаар Шарк танк зэрэг телевизийн шоу болон бусад стартапын салбарын эвент зэргийн үр дүнд стартапын талаарх ойлголт нэмэгджээ.

1. Стартапууд хөгжлийн үе шатаар

Санаа / бета протайп хөгжүүлэлтийн шатанд байгаа стартап 24%-ийг, орлого олж эхлэхээс шинэ зах зээл рүү тэлэх үе шатанд байгаа стартап 69%-ийг эзэлж байгаа бол 7% нь өөрсдийгөө тогтворжилтын үе шатанд орсон гэж үзжээ.




Боловсролын үйлчилгээний хэрэгцээ өндөр байгаагаас шалтгаалан Боловсролын технологийн компаниуд тооны хувьд давамгайлж байгаа бол орлогын хувьд Финтек, Блокчэйн компаниуд тэргүүлж байна.

2. Стартапууд салбараар (давхардсан тоогоор)



Судалгаанд хамрагдсан стартапуудад боловсролын технологийн стартапууд (36%) давамгайлж, дараа нь AI, их өгөгдөл, аналитик (26%), маркетингийн технологийн (25%) стартап орж байна.

3. Орлогоороо тэргүүлж буй стартапын 5 салбар (сая төгрөгөөр)



Гүйцэтгэл

Стартапын экосистемийн үнэлгээ (судалгаанд хамрагдсан стартапуудын дүнгээр) ойролцоогоор 424 тэрбум төгрөг байна (ДСЭТ-ийн арга зүй: Экосистемийн үнэлгээ = гарах үеийн үнэлгээ болон стартапын тооцсон үнэлгээний нийлбэр). Экосистемийн үнэлгээг ярилцлагын явцад стартапуудын өгсөн хариултад үндэслэн тооцсон бөгөөд үүнийг баталгаажуулах боломжгүй. Тиймээс энэхүү тооцоолол нь салбарын бодит үнэлгээ бус салбарын потенциал үнэлгээнд тулгуурласан болно. Түүнчлэн, дээш, доош хазайх хазайлтыг бууруулахын тулд хариултыг интервалаар авч, интервалын голын утгыг ашигласан болно.

Судалгаанд хамрагдсан стартапуудын 46% нь компанийн үнэлгээгээ өөрсдөө, 10% нь гуравдагч этгээдээр компанийн үнэлгээгээ хийлгэжээ (ихэвчлэн хөрөнгө оруулагч, хурдасгуураас санхүүжилт босгосон болон босгохоор явж байгаа орлого олж эхэлсэн компаниуд). Стартапуудын 44% нь стартапынхаа үнэлгээг хийгээгүй байна.

Судалгаанд хамрагдсан стартапуудын 19 нь буюу 24% өөрийн хөрөнгөө хэсэгчлэн борлуулжээ. Түүний 5 хувь нь анхан зэх зээлд хувьцаагаа гаргасан бол 95 хувь нь томоохон компаниудад хувиараа санал тавих байдлаар борлуулжээ. Нийт гарах үеийн үнэлгээ нь ойролцоогоор 28.2 тэрбум төгрөг байна. **Гарах үеийн дундаж үнэлгээ нь үүсгэн байгуулагчдын анхны хөрөнгө оруулалтаас 12 дахин өндөр байна.**

Санхүүжилт

Стартапуудын анхны хөрөнгө оруулалтын дундаж 183 сая төгрөг, нийт дүнгээр 13.4 тэрбум төгрөг байна. Санхүүжилтийн хүртээмж хүндрэлтэй асуудал хэвээр байна. Үүсгэн байгуулагчид ялангуяа хөгжлийн эхэн үе шатанд гол төлөв хувийн хадгаламж (74%), найз нөхөд гэр бүлийн дэмжлэг (25%), мөн бусад бизнесийн орлого (17%) болон дотоодын анжел хөрөнгө оруулагч нарын хөрөнгө оруулалт зэрэгт тулгуурлан компаниа байгуулж байна. Тэтгэлэг нь анхны санхүүжилтийн 11 хувийг бүрдүүлдэг бол хурдасгуур, инкубаторуудын санхүүжилт болон зээл тус бүр 6 хувийг бүрдүүлдэг байна. Дотоодын венчур сангууд болон олон улсын анжел хөрөнгө оруулагчид ховор байдаг ба эхэн шатны санхүүжилтийн ердөө 3 хувийг л тэднээс бүрдүүлжээ.

4. Анхны болон явцын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрээр



Стартапуудын 51% нь явцын санхүүжилт авчээ. Стартапууд дунджаар 2 удаагийн (дээд тал нь 10) явцын санхүүжилт авсан бөгөөд нийт 88.9 тэрбум төгрөгийн явцын санхүүжилтийг авчээ. Дундаж явцын санхүүжилтийн хэмжээ 2.3 тэрбум төгрөг байна. Стартапуудын хэлснээр санхүүжилт авахад тулгарсан гол хүндрэл бэрхшээл нь компанийн үнэлгээ (31%), хэлэлцээрийн нөхцлийг зөвшилцөх (16%) болон ажлын харилцаа тогтоох (15%) байжээ.

Амжилттай явж байгаа зарим стартапууд олон улсын томоохон корпораци болон дотоодын венчур сангуудаас 40 тэрбум төгрөгийн санхүүжилтийг босгосон байна. Эерэг талаас нь харвал илүү олон дотоодын венчур компанийн хөрөнгө оруулагчид зах зээлд орж ирж байна. Томоохон хөрөнгө оруулагчдаас дурдвал Эм Си Эс Инвестмент, Шунхлай, ТЕСО гэх мэт байна.

Зах зээлд нэвтрэлт

Стартапууд өөрсдийн зорилтот зах зээлийг голчлон хэрэглэгч рүү чиглэсэн (B2C 75%), түүний дараа бизнес рүү чиглэсэн (B2B 65%), төрийн байгууллага руу чиглэсэн (B2G 18%) гэж тодорхойллоо. Нийлбэр дүнгээр стартапууд дотоодын зах зээлийг 11 их наяд төгрөг гэж тооцжээ.

Гэхдээ, дундаж дотоодын зах зээлийн хэмжээг стартапууд 191 тэрбум төгрөг гэж тооцоолжээ.

Стартапууд дотоодын зах зээлийн нэвтрэлтийн хувьд өөдрөг үзэлтэй байгаа бөгөөд тэд өөрсдийн салбартаа зах зээлийн 15 хувийг (дээд тал нь 80%) эзэмшиж байгаа гэж үзэж байна. Стартапуудын 21.3 хувь нь АНУ, Япон, Солонгос, Төв Ази, Филиппин

зэрэг улс орны олон улсын зах зээлд орсон эсвэл орох төлөвлөгөөтэй байна. Эдгээр стартапуудаас 65 хувь нь зах зээлийн судалгаагаа хийсэн байна.

Судалгаанд хамрагдсан стартапуудын нийт орлого 60 тэрбум төгрөг байжээ. Стартапуудын дундаж орлого 1 тэрбум төгрөг байна. Судалгаанд оролцсон стартапуудын 75 хувь нь орлого олж эхэлсэн байна. Тэдний 64 хувь нь эхний жилдээ орлого олж эхэлсэн бол 15 хувь нь хоёр дахь жилдээ, 21 хувь нь гурав ба түүнээс дээш жилдээ орлого олж эхэлжээ. Орлого олж эхлэхэд дунджаар 1.8 жил, харин ашигтай ажиллаж эхлэхэд дунджаар 3.3 жил зарцуулжээ.

Туршлага, авьяас мэдлэг

Стартапын үүсгэн байгуулагч нарын боловсролын түвшин өндөр байна. Тэдний 48 хувь ахисан түвшний, 44.6 хувь нь ШУТИМ зэрэгтэй байна. Үүсгэн байгуулагчид дунджаар 2.4 стартапыг байгуулсан байна. Үүсгэн байгуулагчид ажиллаж буй салбартаа дунджаар 6.4 жил, бусад салбарт 6.9 жил ажилласан мэргэжлийн туршлагатай байна. Үүсгэн байгуулагчдын 77% нь стартапаа байгуулахад салбарын туршлага, мэдлэг, 57% нь холбоо сүлжээ, 56% нь манлайллын ур чадвар, гадаад хэлний мэдлэг (38%) тусалсан гэж үзжээ.

Стартапуудын 78% нь МТ-ийн мэргэжилтэнтэй ба тэдний сарын дундаж цалин 2.2 сая төгрөг байна. Стартапууд өөрийн багтаа дунджаар таван мэдээллийн технологийн мэргэжилтэнтэй (дээд тал нь 30), үүнээс хоёр нь (дээд тал нь 12) мэргэжлийн гадаад хэлний мэдлэгтэй байна. Стартапуудын 64% нь мэдээллийн технологийн мэргэжилтнүүдээ хувийн танилын харилцаагаараа дамжуулан олж авч, 25% нь их сургуулиудаас элсүүлж, 6% нь хүний нөөцийн компаниудаар дамжуулан, 3% нь код бичдэг курс хичээл зэргээр, 1% нь Github-аас 19% нь зар зэргээс олж авч байна.

Стартапуудын 43% нь дотооддоо 360, олон улсад 10 оюуны өмч бүртгүүлсэн бөгөөд бүгд арилжааны зориулалтаар ашиглагдаж байна.

Стартапууд дунджаар 15 оюуны өмч (дээд тал нь 40) бүртгүүлсэн байна. Стартапууд шинэ санааг оюуны өмч гэж баталгаажуулах, баталгаажуулах процессыг 1 (ямар ч төвөгтэй биш) - 10 (маш төвөгтэй) оноогоор 4.7-оор үнэлэв. Оюуны өмчийн хамгаалалт байхгүй, компьютерын програм / эх кодыг бүртгэх боломжгүй, бүртгэл нь хэт удаан (барааны тэмдэг бүртгүүлэхэд 9 сар шаардагддаг), хэт олон баримт бичиг шаарддаг зэрэг нь голлох бэрхшээл болж байна.

Судалгааны байгууллага, их дээд сургуулиуд нь Инновацийн төвүүд зэрэг инноваци, гарааны бизнесийг хөгжүүлэх тогтолцоог бий болгож, стартапыг бий болгох, санхүүжилтийг хуваарилах, инкубатор / хурдасгуур компаниудтай түншлэл бий

болгоход профессор, оюутнуудын хамтын ажиллагааг дэмжин ажиллаж байна. Их дээд сургуулиудын амжилттай стартапууд авсан санхүүжилтээ эргүүлэн төлдөг. Гэсэн хэдий ч инновацийг компаниудад шилжүүлэх хувь хэмжээ бага хэвээр байна. Их дээд сургуулиудын стартапуудын амжилт 50% ба түүнээс бага байдаг. Инновацийг дэмжих үүднээс лаборатори, судалгааны төвүүдийг шинэчлэх шаардлагатай байна. Их дээд сургуулиудад инноваци, стартапын төвүүдийг бий болгохын тулд дүрэм журам, хүнд суртлыг эрс багасгах хэрэгтэй. Түүнчлэн ШУТИМ мэргэжлээр элсэлт жил ирэх тусам буурч байгааг оролцогчид хэлж байна.

Эерэг тал нь технологийн коллежууд (KOSEN) боловсролын салбарт нэвтэрч байна. Тэд инженер, технологийн мэргэжлийг голлон анхаарч байгаа нь оюутнууд болон профессоруудын дунд стартапын экосистем, сэтгэлгээг бий болгоход их дээд сургууль, судалгааны байгууллагуудтай амжилттай өрсөлдөхөд тусалдаг.

Уялдаа холбоо

Стартапууд хурдасгуур / инкубаторуудтай хамгийн их уялдаа холбоотой ажиллаж байна (66%). Хурдасгуур / инкубаторууд холбоо харилцаа тогтоох, туршлага, мэдлэгээ хуваалцах, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үйлчилгээ авах, санхүүгийн дэмжлэг болон бусад хэлбэрээр гэх мэт олон янзаар хамтран ажиллаж байна. Стартапуудын 55% нь санаагаа тэдэнд танилцуулжээ. Хурдасгуур / инкубаторууд дунджаар нэг стартапд жилд дунджаар 113 сая төгрөгийг зарцуулсан байгаа бол оролцогчдынх нь 55% гаднаас санхүүжилт авчээ.

Стартапуудын 48% нь бусад стартапуудтайгаа хамтран ажилласан бол 44% нь томоохон компаниудтай хэрэглэгч, зах зээлээ олох, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хөгжүүлэх, санхүүгийн дэмжлэг авах, харилцаа холбоо тогтоох зорилгоор хамтран ажиллажээ. Судалгаанд хамрагдсан стартапуудын 28% нь эрдэм шинжилгээний болон судалгааны байгууллагуудтай уялдаа холбоотой ажилладаг гэжээ. Стартапуудын 30% нь төрийн байгууллагуудтай, 26% нь олон улсын байгууллагуудтай холбогдож байжээ. Олон улсын байгууллагатай холбогдох байдал нь төрийн үйлчилгээг цахимжуулах, аж ахуйн нэгжийг дэмжих зэрэг жижиг төслүүдээр хязгаарлагдаж байна. Эдгээр төслийн амжилт нь харилцан адилгүй байгаа бөгөөд стартапууд, бизнес эрхлэгчдийн идэвх чармайлтаас голлон шалтгаалж байна. ЖАЙКА-гийн MonJa хөтөлбөр нь технологийн стартапуудад чиглэсэн, тодорхой зорилго бүхий ганц хөтөлбөр нь болж байна. Эерэг тал нь стартапын үүсгэн байгуулагчид Global Accelerator Network, Founders


Institute, Aspire, Design Thinking, Lean Startup зэрэг олон улсын тэргүүлэгч сүлжээ, стартапын хурдасгуурын хөтөлбөрт оролцох болсноор олон улсын экосистемтэй холбогдох байдал сайжирчээ.

Тэд Seedstars, Startup Weekend, She Loves Tech болон бусад олон улсын стартапын тэмцээн уралдаанд оролцдог байна.


Сорилт, хэрэгцээ

Стартапуудын хувьд шинэ ажилтан элсүүлэх нь тулгардаг гол сорилт юм (63%). Дараа нь хөрөнгө босгох (55%), борлуулалт болон үйлчлүүлэгчдийг олж авах (49%), багийг хөгжүүлэх (38%), дотоод зохион байгуулалт (35%) орж байна.

5. Стартапуудад тулгарч буй сорилтууд




6. Стартапуудад шаардлагатай 5 гол дэмжлэг



Стартапуудад хамгийн их хэрэгцээтэй байгаа таван дэмжлэг: хөрөнгө оруулалтын сан (61%), татварын зохицуулалтыг сайжруулах (54%), татаас/буцалтгүй тусламж (40%), оюуны өмч, инновацийг хамгаалах зохицуулалт (39%), зээл (31%) юм. Эдгээр дэмжлэгээс гадна стартапууд инкубатор / стартапууд (20%), инновацийн төвүүд (13%), хамтын оффис (11%), шагнал (8%) зэрэгт дэмжлэг үзүүлэхийг хүсч байна.

Стартапууд Монголын стартапын экосистемийг хувьсан өөрчлөгдөж байгаа гэж үзэж, экосистемийн хөгжлийг дэмжих үндсэн 5 хүчин зүйлийг тодорхойлсон. Үүнд боловсролтой ажиллах хүч (68%), эдийн засгийн тогтвортой орчин (59%), инновацийн түвшин (41%), хүн амын худалдан авах чадвар (34%), багийн гишүүдийн олдоц (29%).

7. Монголын стартап экосистемийг дэмжих 5 гол хүчин зүйл



Мөн хүмүүсийн хос хэлээр ярих чадвар (25%), бизнес эрхлэх сэтгэлгээний түвшин (25%), төрөөс стартапыг хөгжүүлэх хүсэл эрмэлзлийн түвшин (21%), банкны тогтвортой орчин (20%), зөвлөх үйлчилгээний хүртээмжтэй байдал (14%) газарзүйн байршил (8%) зэрэг үзүүлэлтүүдийг дурдсан байна. Эдгээр нь бүгд Монголын стартапын экосистемийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна.

Монгол Улсын стартап экосистемийг хувийн сектор хөгжүүлнэ гэж үзэж байна. Одоогийн экосистемийн дутагдалтай тал гэж үзэх гол хүчин зүйл нь бодлого, зохицуулалттай холбогдож байна. Оролцогч талууд хууль тогтоомжоор стартапыг тодорхойлж байгаа байдал нь тодорхойгүй, экосистемийн зөөлөн дэд бүтэц, төрийн хүнд суртал, хүний нөөцийн дутагдал байдал зэргийг дурдаж байсан. Оролцогч талууд эхэн үе шатанд татвараас чөлөөлөх, давхар татвар ногдуулалтыг сайжруулах, венчур хөрөнгө оруулагч, анжел хөрөнгө оруулагчдыг дэмжих хөрөнгө оруулалтын зохицуулалт зэргийг багтаасан судалгаатай, урт хугацааны бодлого хэрэгтэй байгааг дурдаж байсан. **Стартап экосистемийн хөгжлийн талаар бодлого зохицуулагчид, төрийн байгууллагууд харьцангуй сөрөг хандлагатай байна.** Тэдний үзэж байгаагаар инновацийг эдийн засгийн эргэлтэд оруулах зохицуулалт, үйл явцыг сайжруулах хэрэгтэй байна. Хандивлагчид стартапын хөгжлийг хурдасгахад **стартапын экосистемийг хөгжүүлэх төрийн хүсэл эрмэлзэл чухал** гэж үзэж байна. Тэд мөн төрийн үүрэг бол стартапын экосистемийн өсөлтийг дэмжих судалгаатай, таатай бодлого, зохицуулалтыг бий болгох явдал гэж үзэж байна.

Стартапын экосистемийг хөгжүүлэх зөвлөмж

Суурь судалгаагаар Монгол Улсын экосистемийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх 4 үндсэн чиглэлийг тодорхойлсон.

01 **Стартапын эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлого, зохицуулалтыг бий болгох**

Стартапын экосистемийг хөгжүүлэхэд төрийн хүсэл эрмэлзэл чухал. Үүнтэй олон улсын хандивлагч байгууллагууд болон бүхий л оролцогч талууд санал нэгдэж байна. Стартапууд, судалгааны болон төрийн байгууллагууд хуульд заасан стартапын тодорхойлолт хэт хуучирсныг өөрчлөх шаардлагатай, их сургууль, коллеж инновацийг эдийн засгийн эргэлтэд оруулах зохицуулалтыг шинэчлэх шаардлагатай гэж үзснийг энд дурдах хэрэгтэй. Инновацийн асуудал Боловсрол, шинжлэх ухааны яаманд байхад, шинээр байгуулагдсан Эдийн засаг, хөгжлийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны чиг үүрэг давхацсан байгааг өөрчилж, стартапын экосистемийг хөгжүүлэхэд төрийн оролцоог тодорхой болгох шаардлагатай байна.

02 **Стартап, хөрөнгө оруулагчдыг дэмжих хөшүүргийг бий болгох**

Хөрөнгө оруулалтын сан, татварын зохицуулалтыг сайжруулах нь Монголын стартапын эдийн засгийн өсөлтийг дэмжих гол хүчин зүйл болж байна. Ярилцлагын явцад гарсан мэдээллээс үзэхэд стартапын салбар эдийн засгийн төрөлжилтийн гол хөдөлгөгч хүч болж өсөхөөр байна. Хөрөнгө оруулалтын таатай зохицуулалт, татварын орчныг бүрдүүлснээр гадаад шууд хөрөнгө оруулалт, технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийн төрөлжилт бий болно.

03 **Стартапын эко системийн уялдаа холбоог хангах**

Олон улсын стартапын экосистем, зах зээлтэй холбогдох нь стартапын өсөлтийн гол хүчин зүйл болдог. Ази, Европыг холбосон томоохон улсад хамаарч байгаа нь хөшүүрэг болно. Япон зэрэг бусад улс орны стартапын экосистемтэй хамтран ажиллах нь экосистемийн хөгжих эх үүсвэр болж, дэлхийд өөрсдийн потенциалгаа харуулах арга зам болно. Тэргүүлэх стартапын экосистемийг амжилттай хөгжүүлж чадсан Литва, Эстони зэрэг бидэнтэй ижил түвшний экосистемээс бид суралцах хэрэгтэй.

04 **Инноваци, ажиллах хүчнийг дэмжих ШУТИМ-ын боловсролын шинэтгэл**

Боловсролтой, ур чадвартай ажиллах хүчин Монголын стартапын экосистемийн хөгжилд чухал ач холбогдолтой. Чадварлаг багийг бүрдүүлэх нь Монголын стартапуудад тулгамдаж буй гол сорилт болж байна. ШУТИМ мэргэжлээр элсэн суралцагчдын тоо буурч байгаа нь төрөөс ШУТИМ боловсролын шинэтгэл хийх шаардлагатайг харуулсан үзүүлэлт болж байна. 15 наснаас нь 5 жилийн инженерийн боловсрол олгодог Косэн технологийн коллежийн загвар Японы аж үйлдвэржилт, инновацийн хөдөлгөгч хүчин зүйлс болсон. Монгол Улс стартапын экосистемийг дэмжихийн тулд ур чадвартай ажиллах хүчнийг бий болгох үүнтэй адил бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай.